



ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар A/03


Улаанбаатар хот

2023 онд хүнсний бараа, бүтээгдэхүүн  
худалдан авах төлөвлөгөө батлах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90, 2021 оны 102, 2017 оны 337 дугаар тогтоол, “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын дурмийн 4.1 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу 2023 онд Баянзүрх, Хан-Уул дүүргийн цэцэрлэг, сургуулиудад нийлүүлэгдэх хүнсний бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах төлөвлөгөөг нэр төрөл, төсөвт өртгийн хамт хавсралтаар баталсугай.

2. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсны үндсэн дээр шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгуулагуудтай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн дагуу гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахыг (менежер Б.Зоригдоо)-д, худалдан авах бараа бүтээгдэхүүнийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг ерөнхий нягтлан бодогч (Ш.Огтонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.



3130600003